

БАТЛАВ:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.03.06

Д/д	Арга хэмжээ	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах гишүүн
1.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Ёс зүйн дэд хороо"-нд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, дүгнэлт гаргах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, гомдол мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу шалган хуралдаанаар хуульд заасан хугацааны дотор хэлэлцэн дүгнэлт гаргасан гомдол мэдээллийн тоо байна.	Тухай бүр	Бүх гишүүд
2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг болон харьяа Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн түгээх	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постерийг улиралд 2-оос доошгүй удаа гарган, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг болон харьяа Нийгмийн даатгалын газруудад хүргүүлж түгээсэн байна.	Улирал бүр	Д.Тэмүүжин, Мө.Гэрэлмаа
3.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайлан, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайланг Ёс зүйн хорооны баталсан маягтын дагуу улирал бүр, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг дараа оны нэгдүгээр улиралд батгаан Ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.	Улирал бүр	Д.Тэмүүжин
4.	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргүүлсэн тоо байна.	Тухай бүр	Бүх гишүүд

5.	Нийгмийн даатгалын байгууллагын нийт албан хаагчид болон удирдах ажилтнуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалт, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд “Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах	Нийт албан хаагчид, салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.	II, III улиралд	Б.Даваахүү Мө.Гэрэлмаа
6.	“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлуулах	“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн байна.	II улиралд	Ма.Гэрэлмаа Б.Зул
7.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан албан хаагчийн ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулан танилцуулах.	II улиралд	Д.Тэмүүжин, Мө.Гэрэлмаа
8.	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгийг архивын асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх, харьяа Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороонд арга зүйн зөвлөгөө хүргэх	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгээр архивын хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байна.	IV улиралд	Д.Тэмүүжин
9.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх санал, зөвлөмжийг Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэх	Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнд үндэслэн зөвлөмж хүргүүлэх	II улирал	Д.Тэмүүжин Мө.Гэрэлмаа